



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/НБ

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн, 5.2 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8.1.12.13, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох (1) хуулийн этгээдийн нэрийг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох (1) хуулийн этгээдийн нэрийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн нь тогтоогдвол тусгай зөвшөөрлийг цуцалж хуулийн этгээдэд мэдэгдэхийг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200444



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 09 сарын 27 ны өдрийн 172 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ШИНЭЭР ОЛГОХ ХУДАЛДААНЫ ГАЗРЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

№	Д/д	Хуулийн этгээд	Хуулийн этгээдийн РД	Албан тушаал, нэр	Оноосон нэр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг байршил
1	2	3	4	5	6	7	8	9	10
10	1	Рашхүнд ХХК	5503183	Захирал Ж.Маралгоо	Хотын залуус	Мини маркет	06:00- 00:00	1	Өндөртолгой (12330) Гудамж 21 тоот



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны... сарын... нөдрийн... Дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ШИНЭЭР ОЛГОСОН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

№	Д/д	Хуулийн этгээд	Хуулийн этгээдийн РД	Албан тушаал, нэр	Оноосон нэр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг байршил
1	2	3	4	5	6	7	8	9	10
02	1	Рашхүнд ХХК	5503183	Захирал Ж.Маралгоо	Хотын залуус	Баар/караоке	14:00- 04:00	1	Өндөртолгой (12330) Гудамж 21 тоот